



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын хүүхдийн 3-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/152/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Архангай аймаг
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх
аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азхүү
Цахим хаяг: Azkhuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.9 Завсрын аудитын үр дүн	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Г ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН
3-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ДЭНЗЭДМАА ТАНАА

Аудит. ор. дс № 124
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *J. Amals* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,732,603.00	39,690,637.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,732,603.00	39,690,637.00
35100	Түүхий эд материал	422,800.00	1,152,860.00
35130	Эм боох материал	422,800.00	1,152,860.00
35400	Хангамжийн материал	38,309,803.00	38,537,777.00
35410	Бичиг хэргийн материал	328,800.00	288,800.00
35420	Аж ахуйн материал	36,724,276.00	36,801,046.00
35450	Барилгын засварын материал	1,256,727.00	676,000.00
35460	Хүнсний материал	0.00	771,931.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	26,007,125.04	36,539,617.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,007,125.04	36,539,617.42
39200	Биет хөрөнгө	24,544,625.04	35,519,617.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,000,000.00	3,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,425,000.00	-1,575,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	52,584,851.00	60,409,141.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,369,753.78	-40,901,256.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,923,110.31	43,891,310.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,683,192.49	-30,819,187.48
39217	Ном	1,514,610.00	1,514,610.00
39300	Биет бус хөрөнгө	1,462,500.00	1,020,000.00
39301	Програм хангамж	2,267,500.00	2,267,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-805,000.00	-1,247,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	64,739,728.04	76,230,254.42
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	64,739,728.04	76,230,254.42
51	Засгийн газрын хувь оролцоо	64,739,728.04	76,230,254.42
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,879,574.60	15,879,574.60
51200	Хуримтлагдсан үр дүн	47,312,316.39	58,802,842.77
51210	Өмнөх үеийн үр дүн	40,494,841.89	47,312,316.39
51220	Тайлант үеийн үр дүн	6,817,474.50	11,490,526.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,547,837.05	1,547,837.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	64,739,728.04	76,230,254.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	323,439,113.00	340,306,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,847,113.00	7,106,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,847,113.00	7,106,150.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,847,113.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,847,113.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	6,974,290.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	131,860.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	312,592,000.00	333,200,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	273,998,200.00	293,443,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	273,998,200.00	293,443,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	172,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	315,000.00	172,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,278,800.00	39,584,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,278,800.00	39,584,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	316,621,638.50	328,816,223.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	316,621,638.50	328,816,223.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,090,578.50	323,685,272.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,686,600.00	225,147,000.00
210101	Үндсэн цалин	161,498,400.00	164,854,800.00
210102	Нэмэгдэл	36,969,100.00	39,864,800.00
210104	Урамшуулал	20,219,100.00	20,427,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,522,400.00	30,394,900.00
210201	Тэтгэврийн даатгал	20,775,000.00	21,389,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,186,800.00	2,251,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,749,500.00	1,801,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	437,400.00	675,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,373,700.00	4,277,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,187,113.00	30,691,989.00
210301	Гэрэл, цахилгаан	2,029,752.00	2,115,131.00
210302	Түлш, халаалт	25,496,857.00	27,196,647.00
210303	Цэвэр, бохир ус	5,660,504.00	1,380,211.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,114,333.50	8,066,080.00
210401	Бичиг хэрэг	1,760,250.00	1,351,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	373,000.00	402,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	124,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	167,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,961,083.50	5,871,180.00
2105	Нормативт зардал	15,812,955.50	15,584,379.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	5,901,000.00
210502	Хоол, хүнс	15,812,955.50	9,683,379.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,818,090.00	3,651,527.00
210604	Урсгал засвар	3,818,090.00	3,651,527.00
2107	Томилолт, зочны зардал	120,800.00	78,000.00
210702	Дотоод албан томилолт	120,800.00	78,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,394,855.00	811,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,144,855.00	711,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,433,431.50	9,259,997.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	754,100.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,679,331.50	9,259,997.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,531,060.00	5,130,951.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,100.00	150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,100.00	150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,821,811.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,821,811.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,392,960.00	3,159,140.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,392,960.00	3,159,140.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,817,474.50	11,490,526.38
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,817,474.50	11,490,526.38

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,879,574.60	1,547,837.05	40,494,841.89	57,922,253.54
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,879,574.60	1,547,837.05	40,494,841.89	57,922,253.54
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,817,474.50	6,817,474.50
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,879,574.60	1,547,837.05	47,312,316.39	64,739,728.04
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,879,574.60	1,547,837.05	47,312,316.39	64,739,728.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,879,574.60	1,547,837.05	47,312,316.39	64,739,728.04
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	11,490,526.38	11,490,526.38
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	15,879,574.60	1,547,837.05	58,802,842.77	76,230,254.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	312,592,000.00	333,200,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	312,592,000.00	333,200,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	273,998,200.00	293,443,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	273,998,200.00	293,443,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	172,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	315,000.00	172,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,278,800.00	39,584,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,278,800.00	39,584,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	311,502,500.00	320,382,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	311,502,500.00	320,382,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307,971,440.00	315,251,449.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,684,000.00	225,147,000.00
210101	Үндсэн цалин	161,498,400.00	163,014,501.00
210102	Нэмэгдэл	36,969,100.00	40,913,122.00
210104	Урамшуулал	20,216,500.00	21,219,377.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,522,400.00	30,394,900.00
210201	Тэтгэврийн даатгал	20,775,000.00	21,389,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,186,800.00	2,251,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,749,500.00	1,801,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	437,400.00	675,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,373,700.00	4,277,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,990,800.00	30,691,989.00
210301	Гэрэл, цахилгаан	4,198,100.00	2,374,693.00
210302	Түлш, халаалт	25,492,300.00	26,612,633.00
210303	Цэвэр, бохир ус	4,300,400.00	1,704,663.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,268,900.00	2,906,500.00
210401	Бичиг хэрэг	876,000.00	1,081,300.00
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,026,700.00	402,000.00
210404	Ном, хэвлэл	238,400.00	48,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	167,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,007,800.00	1,057,600.00
2105	Нормативт зардал	16,293,540.00	17,421,460.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,035,300.00	6,517,200.00
210502	Хоол, хүнс	14,918,940.00	10,821,260.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	339,300.00	83,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,288,000.00	7,070,800.00
210604	Урсгал засвар	4,288,000.00	7,070,800.00
2107	Томилолт, зочны зардал	62,400.00	78,000.00
210702	Дотоод албан томилолт	62,400.00	78,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,303,700.00	631,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,053,700.00	531,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	557,700.00	909,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,200.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	404,500.00	909,400.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,531,060.00	5,130,951.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,100.00	150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,100.00	150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,821,811.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,821,811.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,392,960.00	3,159,140.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,392,960.00	3,159,140.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,089,500.00	12,818,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,089,500.00	12,818,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,089,500.00	12,818,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,089,500.00	12,818,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,089,500.00	12,818,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,089,500.00	-12,818,200.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	333,028,300.00	328,047,349.00	4,980,951.00	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	333,028,300.00	328,047,349.00	4,980,951.00	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,878,300.00	327,897,349.00	4,980,951.00	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,147,000.00	225,147,000.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	164,854,800.00	163,014,501.00	1,840,299.00	98.9
210102	Нэмэгдэл	39,864,800.00	40,913,122.00	1,048,322.00	102.6
210104	Урамшуулал	20,427,400.00	21,219,377.00	-791,977.00	103.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,394,900.00	30,394,900.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	21,389,000.00	21,389,000.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,500.00	2,251,500.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,801,200.00	1,801,200.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	450,300.00	675,400.00	-225,100.00	150.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,502,900.00	4,277,800.00	225,100.00	95.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,513,800.00	30,691,989.00	1,821,811.00	94.4
210301	Гэрэл, цахилгаан	3,931,000.00	2,374,693.00	1,556,307.00	60.4
210302	Түлш, халаалт	25,437,800.00	26,612,633.00	1,174,833.00	104.6
210303	Цэвэр, бохир ус	3,145,000.00	1,704,663.00	1,440,337.00	54.2
2104	Хангамж, бараа материалын зардал	2,801,500.00	2,801,500.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	976,300.00	976,300.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	402,000.00	402,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	48,200.00	48,200.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	167,400.00	167,400.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,057,600.00	1,057,600.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	30,298,800.00	27,139,660.00	3,159,140.00	89.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,517,200.00	6,517,200.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	13,980,400.00	10,821,260.00	3,159,140.00	77.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,801,200.00	9,801,200.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,070,800.00	7,070,800.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	7,070,800.00	7,070,800.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	78,000.00	78,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	78,000.00	78,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	564,100.00	564,100.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	464,100.00	464,100.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00	0.00	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,009,400.00	4,009,400.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,009,400.00	4,009,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,000.00	150,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,000.00	150,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	150,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	333,028,300.00	328,047,349.00	4,980,951.00	98.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	293,443,700.00	290,284,560.00	3,159,140.00	98.9
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293,443,700.00	290,284,560.00	3,159,140.00	98.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,584,600.00	37,762,789.00	1,821,811.00	95.4
320001	Орон нутгийн төсвөөс	39,584,600.00	37,762,789.00	1,821,811.00	95.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12	12	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	120	120	0.00	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	120	120	0.00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	120	120	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	11	11	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	172,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	172,300.00
210401	Бичиг хэрэг	175,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	172,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	172,300.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын хүүхдийн 3-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азхүү гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 3-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын хүүхдийн 3-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харъяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага юм.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 3-р цэцэрлэг нь “Боловсролын салбарын хөгжлийн бодлогод нийцүүлэн, төрийн албан хаагчийн ёсзүй, хариуцлага, дэг журмыг дээдлэн сахиж, хүүхэд нэг бүрийн бие даасан байдлыг дэмжсэн таатай орчинд тэдний авьяас чадварыг нээн илрүүлэх шилдэг арга зүйтэй, мэргэшсэн чадварлаг боловсон хүчинтэй, эцэг эх, олон нийтийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн хүүхдэд ээлтэй байгууллага болох” гэсэн зорилготой үйл ажиллагаа явуулдаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 333.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 17.7 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	хувь
Б	1	2	3=2-1	4=3/1*100
Бараа материал	38.7	39.7	1	2.58
Үндсэн хөрөнгө	26.0	36.5	10.5	40.38
Нийт хөрөнгө	64.7	76.2	11.5	17.77
Өр төлбөр	0	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	64.7	76.2	11.5	17.77
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	64.7	76.2	11.5	17.77

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 2.5 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь эхний үлдэгдлээс 38.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 27.2 сая төгрөг, хандиваар авсан 0.1 сая төгрөг нийт 27.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 26.4 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 39.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 40.3 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь эхний үлдэгдлээс 26.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 12.8 сая төгрөг, хандиваар ирсэн 6.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 9.2 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр тус тус буурч 36.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд 11.5 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10.8	7.1	-3.7
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	274.0	293.4	19.4
Нэмэлт санхүүжилт	0.3	0.2	-0.1
Орон нутгийн төсвөөс	38.3	39.6	1.3
Үйл ажиллагааны орлого	323.4	340.3	16.9
Цалин, шимтгэлийн зардал	248.1	255.4	7.3
Бараа ажил үйлчилгээний зардал	58.3	58.3	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1.3	0.8	-0.5
Бараа үйлчилгээний бусад зардал	5.4	9.2	3.8

Урсгал шилжүүлэг	3.5	5.1	1.6
Хөрөнгийн зардал			0.0
Үйл ажиллагааны зардал	316.6	328.8	12.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6.8	11.4	4.6

Хүүхдийн 3-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 16.9 сая төгрөгөөр өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 350.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 17.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 333.0 сая төгрөгөөр хянаж баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 333.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр санхүүжилтээ бүрэн авч 328.0 сая төгрөгийг зарцуулж 4.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлэх шилжүүлэг нь хүүхдийн хоол болон тогтмол зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсролын газраас ариутгал халдваргүйжүүлэлт, бичиг хэргийн зардалд 0.1 сая төгрөг ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант жилд ковид-19 цар тахалын улмаас хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа бүрэн явагдаагүй бөгөөд 4 сар үйл ажиллагаа явуулж хоолны зардалд 10.8 сая

төгрөгийг зарцуулж, анх батлагдсан төсвөөс 3.2 сая төгрөг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 333.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тайлант жилд хоол хүнс болон нормативт зардалд 4.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
- Албан конторын тавилгын зардалд 2.5 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Ковид-19 цар тахалтай холбоотой ААН, иргэдээс 0.1 сая төгрөгийн бараа материал, 6.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар хүлээн авсан байна.
- Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хүүхдийн 3-р цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 142 мэдээллээс 35 мэдээллийг хугацаа хоцроосон, өмч хөрөнгө зарцуулах 20.1 сая төгрөгийн 6 тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мэдээллүүдийг нөхөн байршуулах албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант жилд албан конторын тавилгын зардалд 2.5 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т "... албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалт зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүүхдийн 3-р цэцэрлэгийн 2021 оны 3-р улирлын санхүүгийн баримт завсрын аудитад хамрагдсан бөгөөд нийт 2.9 сая төгрөгийн зөрчилд аудитын шийдвэр хүргүүлж биелэлтийг хангуулсан байна. Үүнд:

- 2.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авахдаа хүлээн авах комисс томилоогүй, хүлээн авсан акт үйлдээгүй.

- 2021 оны 6, 7, 8 сарын цалин болон ээлжийн амралтын цалингийн тооцооллыг хийхдээ ХХОАТ-ын хөнгөлөлтийг буруу тооцоолсоноос гарт олгох 0.4 сая төгрөгийн цалинг дутуу олгосон.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22.6 сая төгрөгийг зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хүүхдийн 3-р цэцэрлэг										
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Хүүхдийн 3-р цэцэрлэг	2	22.6					2	22.6		
НИЙТ ДҮН		2	22.6					2	22.6		